

баталгаа бүхий орчуулга хавсаргаагүй боловч хэрэн хулээн авагч иргэн зөвшөөрвөл уг бичиг баримтыг хулээн авч байгаа шуух туунд гардуулан өгч болно.

S. Бичиг баримтыг хулээн авсан, хулээлгэн егсөн хуний гарын усэг зурж он, сар, өдөр бичээд шуухийн тамга дарснаар, зсхул уг бичиг баримтыг хэзээ, ямар хэлбэрээр гардуулсан тухай шуухийн албан ёсны магадлага гаргаснаар бичиг бариш: гардуудсныг батална.

Арван зургадугаар зуйл

1. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвөгэрт байгаа өөрийн харьяат нарт дипломат төлөөлөгчийн буюу консулын газраараа дамжуулан бичиг баримтыг гардуулах эрхтэй.

2. Энэ зуйлийн-1 дэх ангид зааснаар бичиг баримтыг гардуулахдаа албадлагын ямар нэг хэлбэрийг хэрэглэж болохгүй.

Арван долдугаар зуйл

Эрхийн туслалцаа үзүүлэхтэй

холбогдсон зардал

1. Даалгавар хулээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд эрхийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг төлуулэх талаар шаардлага тавихгүй* Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд тус тусын нутг дэвөгэр дээр эрхийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон бух зардал, мөн туунчлэн хэргийн нотлох баримт гаргахтай холбогдсон зардлыг өөрсдөө хариуцна.

2. Даалгавар хулээн авч байгаа байгууллага бух гарсан зардлын хэмжээг даалгавар огч байгаа байгууллагад мэдэгдэнэ. Даалгавар өгч байгаа байгууллага хэрэв уг зардлыг төлөх уурэг бүхий иргэнээс гаргуулж авбал туунээ Хэлэлцэн Тохирогч Этгээд өөртөө үлдээнэ.